



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 4/26

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрх олгох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэхь заалт, “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монголын хөрөнгийн биржийн гишүүн “Батс УЦК” ХХК-ийн ажилтан /Л.Итгэлт/-д үнэт цаасны арилжаанд оролцох эрх шинээр олгосугай.
2. Арилжаанд оролцох эрх авсан гишүүн УЦК-ийн ажилтанд Монгол улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Үйл ажиллагааны газрын Арилжаа бүртгэлийн алба /Д.Тогтохбаяр/-нд, тушаалын биелэлтэд Хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Х.АЛТАЙ

